

ДАХИН ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

2023.10.03

Алтай хот

Дараах автомашиныг аймгийн ИТХ-ын 2023 оны 57 дугаар тогтоолын дагуу үнэ бууруулж дахин дуудлагын худалдаагаар худалдах тул иргэд та бүхнийг дуудлагын худалдаанд өргөнөөр оролцохыг урьж байна.

Үүнд:

№	Хөрөнгийн нэр, төрөл	Үйлдвэрлэсэн огноо	Ашиглалтанд орсон огноо	Ашигласан жил	Дуудах доод үнэ /төгрөг/
Автомашин					
1	Бугат сумын ЗДТГ, УАЗ хантер ГАА88-48	2018	2019	5	6.150.000

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ: Үүнд:

- Иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан байна/.
- Дуудлагын худалдаанд орох хүсэлт /Батлагдсан маягтыг бөглөх/
- Дэнчин тухайн хөрөнгийн дуудах доод үнийн 25% байх бөгөөд дэнчинг байгууллагын "Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын нэмэлт санхүүжилтийн 100050051424" тоот дансанд тушааж, баримтыг материалд хавсаргана.

Дуудлагын худалдаанд оролцох иргэд, хуулийн этгээд дээрх бичиг баримтыг бүрдүүлэн дугтуйд хийж битүүмжлээд, дугтуйны гадна талд худалдан авах хөрөнгийн нэр, төрлийг бичсэн байна.

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ГАРГАХ:

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтээ аймгийн Нутгийн удирдлагын ордонд байрлах Орон нутгийн өмчийн газрын 105 тоот өрөөнд байрлуулсан лацтай хайрцагт зар гарсан өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 18:00 цагаас өмнө хийсэн байна.

Дуудлагын худалдааг 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 10:00 цагт Говь-Алтай аймгийн Нутгийн удирдлагын ордны хурлын танхимд зохион байгуулна.

Худалдан авах хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дуудлага худалдаанд оролцох хүсэлтийн маягтыг Орон нутгийн өмчийн газрын 105 тоот өрөөнөөс авна уу.

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Нээлттэй дуудлагын худалдаанд зарлагдсан хөрөнгийг дуудлага худалдаанд оролцох иргэд, хуулийн этгээд хөрөнгийг өөрийн биеэр сайтар үзэж танилцан, сонголтоо хийнэ үү.
- Дуудлагын худалдаа зарласан цагтаа эхлэх тул оролцогч иргэд, хуулийн этгээд та бүхэн хугацаа хоцрохгүй байхыг анхааруулж байна.

Жич: Төрийн сангийн гүйлгээ цахимаар хийгдэж байгаа тул дэнчингийн мөнгийг буцааж авах иргэд Татварын удирдлагын нэгдсэн системд харилцах дансаа заавал бүртгүүлсэн байх шаардлагатай. Гүйлгээг ажлын 3 хоногт багтаан хийгдэнэ.

/УАЗ хантер ГАА88-48 дугаартай автомашин Бугат суманд байгаа.

